5 138

# МОНГОЛ УЛСЫН
# БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
# САЙДЫН ТУШААЛ

2012 оны 03 сарын 15 өдөр Дугаар 118 Улаанбаатар хот

Тэтгэлэг олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам"-ын 4.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хоёр Улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу Оросын Холбооны Улсад балетын жүжигчний мэргэжлээр амьжиргааны тэтгэлэггүйгээр суралцаж байгаа суралцагчдын амьжиргааны тэтгэлгийг хавсралтад заасны дагуу Сургалтын төрийн сангаас жил бүр олгосугай.

2. Суралцагчдын амьжиргааны тэтгэлгийг тус сургуулиас баталсан тариф, валютын ханшийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэн тооцож жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авч санхүүжүүлж байхыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/, Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Наранцогт/ нарт даалгасугай.

САЙД Ё. ОТГОНБАЯР

C/My doc/OHU oyutan/Perm/oros huuhed tushaal

1101478

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 3 дугаар сарын 15 өдрийн 119 дугаар .... тушаалын хавсралт

**Монголын талаас хариуцах ОХУ-ын Пермь хотын Бүжгийн коллеж-д суралцаж байгаа суралцагчдын тэтгэмжийн зардал**

/мян.төгрөг /

| | Суралцаг-чийн тоо | ОХУ-ын Пермын Улсын бүжгийн коллежийн захирал Л.Д.Шевченкогийн баталсан тариф | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| | | Сарын 1 хүний хоолны зардал - /7000 рубль/ | Сарын 1 хүний Дотуур байрны төлбөр /15 рубль/ | Сарын 1 хүний хэрэглээний цэвэр ус /120 рубль/ | 1 сарын нийт зардал | |
| 1 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 2 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 3 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 4 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 5 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 6 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 9 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 10 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 11 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| 12 сар | 13 | 318.7 | 0.7 | 5.5 | 324.9 | 4,223.7 |
| Дүн | | 3187.0 | 6.8 | 54.6 | 3249.0 | 42,237.0 |

Тайлбар : Ханшийг Монголбанкны 2012.03.11-ны өдрөөр тооцов. 1 рубль = 45.53 төгрөг
Хариуцаж байгаа багшийг 12 хүүхэд дээр нэмж нийт 13 хүнээр тооцов.

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранцогт
Соёл урлагийн бодлогын газрын дарга Б.Наранзун
Мэргэжлийн боловсролын газрын дарга М.Баасанжав
Боловсруулсан З.Баянзул
Хянасан Ж.Отгонбат

МБ 2012.03.20 1 рубль - 45,62

139